



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 7, Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.2.1, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5, 7, 8, 9, 10 дугаар заалт, Хууль зүйн сайдын 2015 оны 1/2063 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Нийгмийн даатгалын байгууллагаас иргэн (хуулийн этгээд)-д мэдээлэл, лавлагаа олгох журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Уртнасан)-т даалгасугай.
3. Даатгуулагч (ажил олгогч)-ийн мэдээллийг бусад байгууллагад олгохгүй байх талаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулж, танилцуулахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Уртнасан)-т үүрэг болгосугай.
4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2013 оны 31 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
5. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (М.Саранчимэг)-нд даалгасугай.

ДАРГА



С.ЭРДЭНЭ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГААС ИРГЭН (ХУУЛИЙН ЭТГЭЭД)-Д МЭДЭЭЛЭЛ, ЛАВЛАГАА ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Зорилго

1.1. Энэ журмын зорилго нь нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагаас (цаашид “байгууллага” гэх) иргэн (хуулийн этгээд)-д өгөх мэдээлэл, лавлагааны төрөл, мэдээлэл өгөх, лавлагаа олгох үйл ажиллагаа, хяналт, хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Хамрах хүрээ

2.1. Энэ журам нь “Нийгмийн даатгалын тухай”, “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай”, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай”, “Шилэн дансны тухай”, “Байгууллагын нууцын тухай”, “Хувь хүний нууцын тухай”, “Өрсөлдөөний тухай”, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай”, “Төрийн нууцын жагсаалт батлах тухай”, “Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай” хуулиуд, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамарч хэрэгжинэ.

2.2. Нийгмийн даатгалын тухай болон эрүүл мэндийн даатгалын хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын байгууллагаас үйлчилгээ авч буй ажил олгогч (даатгуулагч), тэтгэвэр авагч (иргэн) зөвхөн өөрийн мэдээллийг, төрийн бусад байгууллага нь хууль тогтоомж, журамд нийцүүлэн мэдээлэл, лавлагаа авч болно.

Гурав. Байгууллагаас өгөх мэдээллийн төрөл, мэдээллийн ил тод байдлыг хангах

3.1. Байгууллага үйл ажиллагааны дараах мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан ил тод мэдээлнэ. Үүнд:

3.1.1. Байгууллагын эрхэм зорилго, хэтийн зорилго, үнэт зүйл, чанарын бодлого, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл

болон тэдгээрийг хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтэц;

3.1.2. Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7, 7.1.10-д заасан байгууллагын үйл ажиллагаа, танилцуулга, мэдээлэл;

3.1.3. Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийн жагсаалтыг тухайн этгээдийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэрийн хамт;

3.1.4. Салбарын хэмжээнд улсын төсөв, нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр болон гадаадын эзэл, түслэмжээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээлэл;

3.1.5. Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2, 8.1.3, 8.1.4, 8.1.5, 8.1.6-д заасан үйл ажиллагаа, хүний нөөцийн мэдээлэл;

3.1.6. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.4, 6.1.5, 6.1.6-д заасан байгууллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа;

3.1.7. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасан байгууллагын төсөвт орсон намалт, өөрчлөлт, төлбөр, хураамж, үйлчилгээний хөндсний мэдээлэл;

3.2. Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрт түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуульбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5, 8, 9 дүгээр зүйлд заасан мэдээллийг хавсаргасан байна.

Дөрөв. Байгууллагаас лавлагаа гаргаж өгөх

4.1. Байгууллага нь дараах төрлийн лавлагааг зөвхөн иргэн (даатгуулагч)-д өөрт нь, эсвэл итгэмжлэл бүхий этгээдэд гаргаж өгнө. Үүнд:

4.1.1. Даатгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа;

4.1.2. даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны мэдээлэх хуудас;

4.1.3. даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсвэрт тухай Нийгмийн халамжийн байгууллагад гаргах лавлагаа;

4.1.4. даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсч, тэтгэвэр авдаг тухай лавлагаа;

4.1.5. эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ авсан эсэх лавлагаа;

4.2. Байгууллага дараах лавлагааг ажил олгогчийн хүсэлтээр зөвхөн ажил олгогчид гаргаж өгнө. Үүнд:

4.2.1. ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооны тухай лавлагаа;

4.2.2. даатгуулагчийн тоо (монгол болон гадаадын иргэд);

4.2.3. нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогчийн тоо;

4.3. Байгууллага нь энэ журмын 4.2-т дурдсан мэдээллийг журмын 4.8-д нийцүүлэн иргэн, судлаач (хүүлийн этгээд), төрийн болон төрийн бус байгууллагад ерөнхий дүнгээр, нийгмийн даатгалын сангийн сарын болон улирлын тайланд үндэслэн өгч болно.

4.4. Лавлагаа авах тухай иргэн, хүүлийн этгээдийн хүсэлт дараах шаардлага хангасан байна:

4.4.1. хүсэлт гаргах нь иргэн бол эцэг /эх-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын буюу цахим шуудангийн хаяг, утасны дугаар, иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын дугаарыг бичиж, гарын үсгээ зурсан байх;

4.4.2. хүсэлт гаргах нь хүүлийн этгээд бол нэр, хаяг буюу цахим шуудангийн хаяг, утасны дугаарыг бичиж, хүүлийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсгээ зурсан байх;

4.5. Байгууллага нь иргэний үнэмлэхийн, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын дугаараар нь тухайн иргэн, хүүлийн этгээдтэй холбогдох мэдээлэл үнэн зөв эсэхийг шалгаж, лавлагаа авах хүсэлтэд дурдсан мэдээлэл тухайн байгууллагын эзэмшилд байгаа эсэх, байхгүй тохиолдолд тухайн хүсэлтийг холбогдох байгууллагад нь 2 хоногийн дотор шилжүүлж, энэ тухай иргэн, хүүлийн этгээдтэй холбогдох мэдээлэл хуудасны мэдээлэх хуудас;

этгээгдэж мэдэгдэх, мэдээлэл байгаа бол хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд ажлын 7 өдрийн дотор өгөх бөгөөд хүсэлтийг иргэд хамтран гаргасан бол тэдгээрийн төлөөлөгч болох нэг иргэнд мэдээллийг өгнө. Цаардлагагай гэж үзвэл хугацааг нэг удаа 14 хоногээр сунгаж болно.

4.6. Байгууллага мэдээлэл авах төрийн болон бусад байгууллагын саналыг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, мэдээлэл өгөх эсэх асуудлаар шийдвэр гаргуулна.

4.7. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар мэдээлэл солилцохыг зөвшөөрсөн тохиолдолд Байгууллага зөвхөн хамтран ажиглах гэрээ байгуулсны үндсэн дээр мэдээлэл солилцож болно.

4.8. Байгууллага дараах тохиолдолд гавлагаа, мэдээлэл гаргаж өгөхийг үүнд:

4.8.1. хүсэлт гаргах иргэн эгэл /эх-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын буюу цахим шуудангийн хаяг, үгсний дугаар, иргэний үнэмлэх, эсхүл түүнтэй адилтгах бичиг баримтын дугаарыг бичиж, гарын үсгээ зураагүй бол;

4.8.2. хүсэлт гаргах хуулийн этгээд нэр, хаяг буюу цахим шуудангийн хаяг, үгсний бүртгэлийн дугаараа бичиж, хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсгээ зураагүй бол;

4.8.3. хувь хүн бичгээр зөвшөөрснөөс бусад тохиолдолд түүний этгээд /эх-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, мэргэжил, боловсрол, албан тушаал, ажлын газрын хаяг, ажлын үгсний дугаар бусад мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд;

4.8.4. аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шугарга өрөөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор нүүдэллэж хамгаалагдааг авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор үршиг үзүүлж болох нүүд мэдээ, мэдээллийг тухайн аж ахуйн нэгжийн эрх бүхий этгээдийн /үйцэтгэх үйлдвэртэй буюу түүнээс эрх олгосон бусад этгээд/ бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр бусад иргэн, хуулийн этгээдэд;

4.8.5. аль нэг аж ахуй эрхлэгчид давуу байдал олгоход нилсэн мэдээллийг иргэн, хуулийн этгээд хүссэн бол;

4.8.6. нийгмийн даатгалын мэдээллийн сангийн мэдээллийг бусад нь авч ашиглахыг хүссэн бол;

4.8.7. албан ёсоор баталгаажуулах, бүрэн дуусаагүй тайлан тэнцэл, судалгаа, тооцоолол;

4.8.8. мэдээллийн аюулгүй байдлыг хангаагүй, ашиглах сүлжээт холбогдох эрх бүхий байгууллагаар шалгуулаагүй;

4.8.9. "Эдийн засгийн ял гол байдлыг дэмжих тухай" хуулийн хүрээнд тайлагнасан нийгмийн даатгалын шимтгэлийн тайлантай холбоотой бүх

мэдээлэл зэрэг болно.

4.8.10. "Байгууллагын нууцын тухай", "Хувь хүний нууцын тухай", "Өрсөлдөөний тухай" болон бусад хууль тогтоомжийг зөрхсөн, даатгуулагч (ажил олгогч)-ийн эрх ашгийг үл нийцсэн бол;

4.9. Байгууллага нь энэхүү журмын 4.1, 4.2-т дурдсан нөхцөлөөс иргэн (хуулийн этгээд)-д тахимаар гарган өгч болох ба энэ нь хууль ёсны хүчин төгөлдөр баримт бичиг байна.

4.10. Байгууллагаас гаргаж өгсөн лавлагаа нь аливаа нэг санхүүгийн төлбөрийн баримт болохгүй ба санхүүгийн баталгаа, барьцааны зүйл болохгүй.

4.11. Байгууллага нь лавлагааг төлбөртэй гаргаж өгч болох ба үйлчилгээний хөлсний хэмжээг тухайн мэдээллийг өгөх зэрэгтэй нийцүүлэн байгууллагаас тогтооно.

Тав. Лавлагаа олгох

5.1. Энэ журмын 3.1-т дурдсан мэдээллийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Тамгын газар, Төлөвлөлт, санхүү бүртгэлийн газар, Мэдээллийн технологийн төв, аймаг, дүүрэг (нийслэл)-ийн нийгмийн даатгалын хэлтэс (газар), сүм (тасаг)-ын нийгмийн даатгалын байцаагч (ажилтан) гаргана.

5.2. Энэ журмын 4.1, 4.2-т дурдсан лавлагааг Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүрэг (нийслэл)-ийн нийгмийн даатгалын хэлтэс (газар), сүм (тасаг)-ын нийгмийн даатгалын байцаагч (ажилтан) гаргана.

5.3. Энэ журмын 4.6-д дурдсан ажлыг зөвхөн Нийгмийн даатгалын ерөнхий газар хариуцан гүйцэтгэнэ.

- 6.1. Мэдээлэл, лавлагаа олгох үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймаг, дүүрэг (нийслэл)-ийн нийгмийн даатгалын хэлтэс (газар), сум (тасаг)-ын эрх бүхий ажилтан тухай бүр хяналт тавьж ажиглана.
- 6.2. Албан тушаалтан бүрэн эрхийнхээ дагуу олж авсан мэдээллийг хууль бусаар задруулах, албан үүрэг нь хамааралгүй байдлаар ашиглахыг хориглоно.
- 6.3. Энэхүү журмыг зөрсөн албан тушаалтанд Иргэний хууль, Төрийн албаны тухай хууль, Мэдээллийн ил тод байдлын ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу харилцанаа хүлээлгэнэ.